НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

# БОДЛОГЫН АСУУДАЛ

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМААС ЭРХЛЭН ГАРГАЖ БУЙ ЦУВРАЛ

Дугаар № 54

# ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫГ ҮНЭЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ

*Хөгжлийн эрх зүйн төв ТББ*

## АСУУДЛЫН ТОЙМ

*Lex est quod populus iubet atque constituit.*
*(Хууль бол ард түмний тушаалаар тогтоосон зүйл )*

Хууль гарцаагүй хэрэгждэг байх нь эрх зүйн үндсэн зарчим, эрх зүйт ёсыг нийгмийн үнэт зүйл болгодог бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” хэмээн тунхаглажээ. Энэ зарчмын агуулгад хууль гарцаагүй хэрэгждэг байх шаардлага багтана. Хуулийг хүмүүсийн дээд эрх ашиг хэмээн үзэж, нэг мөр ойлгож, баталгаатай хэрэгжүүлдэг байхын тулд Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийг 2015 онд баталсан.

Хэдийгээр онолын дагуу хууль нэгэнт ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл учир өөрөө аяндаа хэрэгжиж байх учиртай гэдэг боловч эрх зүйн хэм хэмжээ хэрэгжихгүй, хүмүүс хуулийг дагаж мөрдөхгүй байх тохиолдол байнга гардаг бөгөөд тухайн хуулийн хэм хэмжээ хүмүүсийн эрх ашигт нийцэж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалж чадахгүй байх, хуулийг хэрэгжүүлэх үйл явцын нарийн төвөгтэй байдал, хэм хэмжээ хоорондын зөрчилдөөн, эрх зүйн хийдэл, хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн болон институцын бүтэцгүй байх, эдийн засгийн эх үүсвэр дутагдах зэрэг олон практик шалтгааны улмаас хуулийн хэрэгжилтийг хангах асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагатай болдог. Энэхүү хэрэгцээ шаардлагын дагуу Монгол Улсад Хууль тогтоомжийн тухай хуулиар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх асуудлыг зохицуулсан байна[1].

[1] Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1.

СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН: “ХӨГЖЛИЙН ЭРХ ЗҮЙН ТӨВ” ТББ

“Хөгжлийн эрх зүйн төв” нь хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ, сургалт, судалгаа хийх зорилго бүхий, 2021 онд байгуулагдсан төрийн бус байгууллага юм.



Г.ЭРДЭНЭБАТ ХУУЛЬЧ, СУДЛААЧ

Эрүүгийн эрх зүй, криминологи, харьцуулсан эрх зүйн чиглэлээр судалгааны ажил эрхэлдэг. Академик болон бодлогын судалгааны чиглэлээр 20 гаруй жил ажилласан туршлагатай.



О.МӨНХЦЭЦЭГ “ХӨГЖЛИЙН ЭРХ ЗҮЙН ТӨВ” ТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ХУУЛЬЧ

Эрүүгийн эрх зүйн чиглэлээр судалгааны ажил эрхэлдэг. Төрийн алба, ёс зүй, жендэрийн тухайлсан чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Энэхүү бодлогын шинжилгээг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж буй байдал, тулгарч буй саад бэрхшээл, сул талыг тодорхойлох, улмаар асуудлыг шийдвэрлэх, бэрхшээлийг даван туулах гарц, шийдлийг олох, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах зорилгоор хийв. Аливаа хууль хэрэгжихгүй байгаа шалтгааныг олж тогтоох, хэрэгжиж байвч энэ нь хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлоох Монгол Улсын Үндсэн хуулиар зарлан тунхагласан зорилгод нийцэж буй эсэхийг цэгнэж үнэлэх шалгуур, хандлагыг энэхүү шинжилгээнд баримталсан болно. Өөрөөр хэлбэл, аливаа хууль үр дүнтэй хэрэгждэг байх, ингэхдээ төрийн байгууллага, албан тушаалтны эрх ашгийг хангахын төлөө бус иргэн, нийгмийн нийтлэг эрх ашиг буюу хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахад зориулагдсан байх учиртай. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх ажил ч энэ шалгуураар хийгдэх ёстой. Үүнийг хууль албан тушаалтанд үйлчлэх буюу “Төрийн хууль” биш иргэнд үйлчлэх “Улсын хууль” байх ёстой гэсэн үзэл баримтлал хэмээн томьёолж, Монгол Улсад хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ (цаашид Үнэлгээ гэх) хийж буй байдлыг шинжлэхэд чиг болгон баримталснаар дараах дүгнэлт, саналд хүрсэн болно. Үүнд:

- Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх аргачлал (цаашид “Аргачлал” гэх), шалгуурыг шинэчлэн хуулийг анх боловсруулах үндэслэл болсон хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлсэн үр нөлөөг үнэлдэг болгох;
- Хууль тогтоомж хүний эрх, эрх чөлөөг хангаж хамгаалах зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэх шаардлагыг нэмж тусгах;
- Хуулийн хэрэгжилтэд хяналт тавихад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын чадавхыг бэхжүүлэх, Үнэлгээ хийхэд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах;
- Төрийн захиргааны төв байгууллагаас хэрэгжүүлэх Үнэлгээнд хөндлөнгийн аудит хийлгэх, эсвэл иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбооны оролцоотойгоор хэрэгжүүлдэг байхаар хууль болон Аргачлалд тусгах;
- Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.5-д заасан “хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүрэн байршуулах”, 52 дугаар зүйлийн 52.1-д заасны дагуу “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дүнг Улсын Их Хурал, Засгийн газар жилд нэг удаа тогтмол хэлэлцэж” хэвших.

## АСУУДЛЫН ТАНИЛЦУУЛГА

Хууль нийгмийн харилцааг зохицуулах үүргээ биелүүлж чадаж байгаа эсэхийг үнэлж, хуулийн давхардал, хийдлийг арилгаж, алдааг засахгүйгээр эрх зүйт ёс төлөвшин тогтож нийгмийн хөгжлийг хангах боломжгүй. Ийм ч учраас “хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх” асуудлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн нэг зорилго болгон хуульчилсан билээ. Улмаар “хэрэв хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бол тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр төсөл боловсруулах[2], ингэхдээ Засгийн газраас баталсан аргачлалын[3] дагуу 5 жил тутам үнэлэх, шаардлагатай бол энэ хугацаанаас өмнө хийх[4], Үнэлгээний дүнг Улсын Их Хурал, Засгийн газар жилд нэг удаа тогтмол хэлэлцэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах,

[2] Хууль тогтоомжийн тухай хууль. 8 дугаар зүйлийн 8.1.1, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг.
[3] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт
[4] Мөн хуулийн. 51 дүгээр зүйл

хууль тогтоомжийг хооронд нь уялдуулах, системчлэн кодификаци хийх, шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр[5] тус тус заасан.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад 933 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнээс 352 нь байнга дагаж мөрдөгдөх шинжтэй, нийгмийн харилцааг тогтвортой зохицуулсан хууль байгаа бол, 257 нь нэг удаагийн асуудлыг зохицуулсан, 197 нь тодорхой хугацаанд үйлчлэх, 127 нь тодорхой хуулийн хэрэгжилтийг хангах зорилго бүхий дагаж мөрдөх журмын тухай хууль байна. ***Харин батлагдаад 5 жилээс дээш хугацаагаар үйлчилж байгаа буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ хийгдсэн байвал зохих 267 хууль байна.*** Харин одоогийн байдлаар нийтэд ил тод тавигдсан, судалгаагаар олж тогтоосон 118 хуулийн Үнэлгээ олдов. Мөн нэг хууль буюу Эрүүл ахуйн тухай хуульд Үнэлгээ хийгдэж буй гэсэн мэдээ байна. Дээрхээс харвал, 267 хуулийн 148-д нь Үнэлгээ хийгдээгүй байна. Байнга үйлчлэх шинжтэй 352 хууль, тэдгээр үнэлгээ хийсэн байдлыг Хавсралтаас үзнэ үү.

Үүнээс үүдэн Монгол Улсад хууль тогтоомж үр нөлөөтэй үйлчилж байна уу, хуулийн хэрэгжилтийг бодитой үнэлж, шаардлагатай засвар, өөрчлөлтийг хийж байгаа юу, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх ажил бодитой хийгдэж байгаа юу, хийгдэхгүй байгаа бол ямар шалтгаанаар хийгдэхгүй байна вэ?, цаашид хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, түүндээ үндэслэн хууль тогтоомжийг боловсронгуй болгон нийгмийн хөгжлийг хангах, эрх зүйт ёсыг тогтоохын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ гэх мэт олон асуулт урган гарч байна. Эдгээр асуултын хариуг олохын тулд дээр дурдсан Үнэлгээ тус бүрийг судалж дүн шинжилгээ хийлээ.

## ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Үүсэн буй асуудлын шалтгааныг тогтоох зорилгоор Хууль тогтоомжийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Монгол Улсын Засгийн газрын "Аргачлал батлах тухай" 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-д дүн шинжилгээ хийв.

Хууль тогтоомжийн тухай хуулиар Монгол Улс хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг төлөвлөх үеэсээ эхлэн тухайн харилцааг зохицуулж байгаа хуульд Үнэлгээ хийсний үндсэн дээр төсөл боловсруулах эсэхийг шийдвэрлэхээр хуульчилжээ[6]. Улмаар хууль санаачлагч Үнэлгээ хийснээр төсөл боловсруулах ажлыг эхэлж[7], түүндээ үндэслэн хууль тогтоомжийн үзэл баримтлал болон төсөл боловсруулах[8], цаашлаад хууль тогтоомжийг өргөн мэдүүлэх шатанд энэхүү Үнэлгээг баримт бичгийн бүрдүүлбэр болгон хавсаргах[9] ба эргээд хууль тогтоомжийн төслийг Үнэлгээнд үндэслэн боловсруулсан эсэхийг хянаж[10] байхаар хуульчилсан байна.

Хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан 6 аргачлалын дагуу эхлээд хуулийн төсөл боловсруулах нийгмийн бодит хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг тандан судлаад улмаар уг хуулийн нийгмийн харилцааг хэрхэн зохицуулах үзэл баримтлал, ийнхүү хууль гаргаснаар нийгэмд авчрах үр нөлөөг урьдчилан үнэлэх, хуулийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд гарах зардлын тооцоог хийх, хуулийг хэрэгжүүлэх явцдаа хяналт-шинжилгээ үнэлгээ хийж явсаар тодорхой хугацаа өнгөрсний дараа хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх гэсэн логик дараалал үүсгэжээ.

---

5 Мөн хуулийн 52 дугаар зүйл
6 Хууль тогтоомжийн тухай хуулийн 7.3
7 Мөн хуулийн 8.1.1
8 Мөн хуулийн 14.1 21.4
9 Мөн хуулийн 15.10, 20.4, 21.1, 40.1.2, 41.3.3,
10 Мөн хуулийн 41.3.3

Тодруулбал, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор:

- Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал[11];
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал[12];
- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал[13];
- Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал[14];
- Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал[15];
- Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг[16] тус тус боловсруулж баталсан.

Үүний дагуу аливаа хууль тогтоомжийн төслийг анхлан боловсруулахдаа энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар тогтоосон аргачлалын дагуу уг хууль тогтоомжийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, батлагдаад нийгэмд үйлчилж буй хуулийн хувьд 6 дугаар хавсралтаар баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу судалж үнэлгээ хийх, улмаар хуулийн төслийг тогтоолын 2 дугаар хавсралтад заасан арга, журмын дагуу боловсруулах, түүнийгээ дагалдуулан уг хууль тогтоомжийн төсөл батлаcнаар хүрэхийг эрмэлзэж буй зорилго, түүний практикт хэрэгжих боломж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо зэргийг тогтоолын 3,4 дүгээр хавсралтад дурдсан аргачлалын дагуу боловсруулахаар журамласан байдаг.

*Бүдүүвч. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шат*




[11] Тогтоолын 1 дүгээр хавсралт
[12] Тогтоолын 2 дугаар хавсралт
[13] Тогтоолын 3 дугаар хавсралт
[14] Тогтоолын 4 дүгээр хавсралт
[15] Тогтоолын 5 дугаар хавсралт
[16] Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт

Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахын тулд энэхүү 6 аргачлалыг хооронд нь нягт уялдаатайгаар, нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлэн хуулийн цогц, системт байдлыг хангах механизм хэмээн хандах нь зүйтэй байна. Гэхдээ энэхүү судалгаа эдгээр бүх аргачлалыг хамруулсан өргөн хүрээнд хийх зорилгогүй тул аргачлалуудын цогц, уялдаат байдлыг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээнд хамаатах байдлаар хязгаарлан үнэлэв.

## Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах Аргачлалууд, тэдгээрийн уялдаа холбоо

Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тандах судалгаа болон шинээр хууль батлахтай холбогдон гарах нийгэм, эдийн засгийн үр нөлөө, зардлын тооцооны талаар бидний энэхүү судалгаанд авч үзээгүй. Эдгээр асуудлыг тухайлан бүүрьтай судалж хэрэгжилт нь ямар түвшинд байгааг үнэлэх шаардлагатай болохыг онцолж байна. Мөн эдгээр Аргачлалууд хоорондоо уялдаатай, нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлж буй байдлыг анхаарч үзэх ёстой. Тухайлбал, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх үнэлгээний анхдагч үзүүлэлтүүд нь 1. “Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлсэн үр нөлөө”, 2. Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой уялдаж буй байдал гэсэн суурь шалгуур үзүүлэлтүүд байхаар байна. Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тандан судлах аргачлалд а) хүний эрхэд үзүүлэх үр нөлөө, б) эдийн засагт үзүүлэх үр нөлөө, в) нийгэмд үзүүлэх үр нөлөө, г) байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тус тус хүснэгтлэн тусгажээ[17]. Харин бидний судлан буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх шалтгааны

- тухайн хууль тогтоомжийг шүүхийн практикт хэрэглэн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хүндрэл, бэрхшээл гарах, ойлгомжгүй, зөрчилтэй зохицуулалттай байх, тэдгээр нь цаашид тухайн харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх шинжтэй байвал;
- хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, эсхүл нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, эсхүл тэдгээрээс улбаалсан сөрөг үр дагавар бий болсон бол;
- захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл үүссэн бол;
- нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар түүнийг өөрчлөх, шинэчлэх, эсхүл хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал гаргасан;
- төрөөс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаарх үүргээ биелүүлэхгүй байгаа буюу Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж байгаа бол;
- тухайн хууль тогтоомжид тодорхой хугацааны дараа түүний хэрэгжилтийн үр дагаврыг тооцохыг тусгасан бол[18] хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж байхаар журамлажээ.

Хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг тандан судлах үедээ хүний эрхийг хангах, хамгаалах, эдийн засгийн өсөлт, хөгжилд хувь нэмэр болох, нийгмийн хөгжлийг хангах, байгаль орчинд хэрхэн нөлөөлөх хэрэгцээ шаардлага байгааг үндэс болгосон атлаа батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэхдээ эдгээр хууль тогтоомжийг баталж мөрдүүлэх үндэслэл болсон үр дүндээ хүрсэн эсэхийг үнэлэхгүй байгаа нь учир дутагдалтай

[17] Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тандан судлах аргачлалын 6.2
[18] Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт. 3.2.

юм. Ялангуяа хууль тогтоомжийн төслийг анх боловсруулахдаа хүний эрхийн суурь зарчмуудад нийцсэн, ялгаварлан гадуурхаагүй, эрх ашиг нь хөндөгдөн буй нийгмийн бүлэг хэсгүүдэд уг хууль тогтоомж хэрхэн нөлөөлөх, хүний эрхийг хангаж хамгаалах үүргийг хэн хүлээхийг тодорхой заасан, жендэрийн тэгш байдлыг хангасан хэмээн тодорхой зааж төслийг боловсруулсан атлаа практикт энэхүү үр нөлөө нь гарсан эсэхийг үнэлэхгүй байгаа нь ихээхэн анхаарал татаж байна.

Хууль хүний эрх ашиг, хүсэл зоригийг хангасан үед хүмүүс түүнийг хүлээн зөвшөөрч, хуулийг дагаж мөрдөж байдаг. Энэхүү судалгааны эхэнд дурдсанчлан "хууль нь ард түмний хүслийг хуульчилсан" үедээ дээдлэгдэж мөрдөгдөх учиртайг үндэс болговол хуулийн хэрэгжилтийг үнэлэхдээ юуны өмнө хүний эрх, эрх чөлөөг хангаж хамгаалж чадаж байгааг нь үнэлэх ёстой. Иймд Аргачлалд дурдсан шалтгаанууд дээр нэмж ***"хууль тогтоомж хүний эрх, эрх чөлөөг хангаж хамгаалах зорилгодоо хүрсэн эсэх"***-ийг үнэлэх шаардлагыг нэмж тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон хуулийн төсөл боловсруулах аргачлалтай бидний судлан буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээг уялдуулан үйлчлэн буй хууль тогтоомжид хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавигдах шаардлагыг хангаагүй нөхцөл байдал илэрсэн эсэхийг тухайлан шалгаж үнэлэх нь зүйтэй. Тодруулбал, дагаж мөрдөж буй хуулиуд:

- Монгол Улсын Үндсэн хууль Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай зөрчилдсөн нөхцөл байдал үүссэн эсэх;
- Зохицуулалтын хийдэл, давхардал үүсгэсэн эсэх;
- Огт хэрэглэгдээгүй буюу нийгмийн харилцааг зохицуулаагүй хэм хэмжээ байгаа эсэх зэрэг шалгуурыг үнэлгээний хүрээнд хамруулах нь зүйтэй байна.

Батлагдсан хууль тогтоомжоо зорилго болон үзэл баримталалаар тодорхойлсон үр дүнд хүрэх байдлыг тогтмол хугацаанд ажиглан тодорхойлох зорилгоор хяналт-шинжилгээ хийх аргачлалыг баталсан[19]. Энэхүү Аргачлалд хяналт-шинжилгээг "аливаа үйл явцын талаар мэдээлэл цуглуулж, ажиглалт хийн зөв чиглүүлэх тасралтгүй үйл ажиллагаа юм. Ажиглаж байгаа үйл явц буюу үйл ажиллагаа нь зорилгодоо хүрэхгүй байх, зорилгоосоо гажих, төлөвлөснөөр хэрэгжихгүй байх тохиолдолд түүнийг чиглүүлэх нь хяналт-шинжилгээний үүрэг мөн" хэмээн тодорхойлж хяналт шинжилгээ хийх зорилго болон тохирох хэмжүүрийг тогтоосон байна. Харамсалтай нь хяналт-шинжилгээг юунд, ямар зорилгоор, яаж хийхийг заасан атлаа хэн, хэзээ, ямар арга хэрэгслээр хийхийг тодорхой заагаагүй байна.

Улмаар Монгол Улсын Засгийн газраас хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээ аргачлалтай нэг талаар давхацсан, нөгөө талаар хуулийн хэрэгжилтийг тухайн хууль батлагдсанаас хойш тодорхой цаг хугацаа өнгөрсний дараа үр дүнг тооцож, хэрэгжилтийг тодорхойлдог бөгөөд хууль тогтоомжийн зорилго болон үзэл баримталалаар тодорхойлсон үр дүнд хүрэх байдлыг тогтмол хугацаанд ажиглан дүгнэлт өгөх замаар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, түүний хэрэгжилтийг үнэлэх нь бодит бус дүгнэлт гарах магадлалтай гэсэн үндэслэлээр 2023 онд хуульд нэмэлт өөрчлөлт оруулж холбогдох зүйлийг хүчингүй болгожээ[20]. Зүй нь энэхүү хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ

[19] Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт.
[20] https://mojha.gov.mn/wp-content/uploads/2021/10/Taniltsuulga-XTTX.pdf

хийх аргачлалыг тогтмол мөрдөж амжилттай хэрэгжүүлж чадсан бол бидний судлан буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил ихээхэн хялбар бөгөөд үр дүнтэй болох учиртай байв.

## Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

Бидний үндсэн судлагдахуун болох Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээний аргачлалыг “хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох” зорилгод үйлчлэхээр боловсруулж баталжээ[21].

Хуульд зааснаар энэхүү Үнэлгээг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын холбогдох яам, харин эрүүгийн, иргэний, захиргааны, зөрчлийн эрх зүйн салбарын хууль тогтоомжийн Үнэлгээг Хууль зүйн үндэсний хүрээлэн эсхүл хөндлөнгийн байгууллага[22] захиалгаар хийхээр хуульчилсан байна.

Харин уг Үнэлгээний аргачлалыг Монгол Улсын Засгийн газар баталж мөрдүүлэхээр заасан[23] байх бөгөөд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор уг аргачлалыг баталсан байна. Мөн хуульд Үнэлгээг 5 жил тутам, шаардлагатай бол түүнээс өмнө хийж болно[24] гэж заажээ. Хуулийн 51 дүгээр зүйлийн хэм хэмжээнд дүн шинжилгээ хийж үзвэл хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулахад, эсвэл УИХ-ын хяналт, шалгалтын хүрээнд болон УИХ-ын гишүүний даалгаснаар Үнэлгээ хийх боломжтой байх ба үүнээс бусад тохиолдолд

А) 5 жил тутам;

Б) шаардлагатай тохиолдолд энэ хугацаанаас өмнө гэсэн хоёр шалгуураар Үнэлгээг хийхээр байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалтаас үзвэл Үнэлгээг:

- ямар субъект (УИХ, Засгийн газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, хөндлөнгийн байгууллага)
- ямар зорилгоор (хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх)
- ямар хугацаанд (5 жил тутам, шаардлагатай бол түүнээс өмнө)
- ямар аргаар (Засгийн газраас баталсан аргачлалын дагуу) хийхээр байна.

Улмаар Үнэлгээний зорилгыг хангахын тулд тогтоосон аргачлалын дагуу дээрх субъектүүд “хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох”[25] зорилтын төлөө ажиллах ёстой ажээ.

Гэсэн хэдий ч УИХ, Засгийн газрын холбогдох яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн хуульд заасны дагуу тогтоосон хугацаанд Үнэлгээ хийсэн баримт хараахан байхгүй.

Судалгаагаар УИХ, түүний холбогдох байнгын хороо Үнэлгээ хийх боломжгүй нь тогтоогдов. Монгол Улсын Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хууль болон бусад хууль тогтоомжид шинжилгээ хийж үзэхэд УИХ, түүний байнгын хороодод Үнэлгээ хийх хүний нөөц, хөрөнгийн

[21] Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт
[22] Хууль тогтоомжийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэг
[23] Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт
[24] Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг
[25] Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтын 1.2 дугаар зүйл

эх үүсвэр байхгүй, зөвхөн УИХ-ын хяналт шалгалтын хүрээнд үнэлгээг сонсох[26] боломжтой байхаар зохицуулсан байна. Бүр тодруулбал, одоогийн байдлаар УИХ, түүний байнгын хороодод Үнэлгээ хийх ажилд зориулсан төсөв, уг асуудлыг хариуцах алба, нэгж, ажилтан, Үнэлгээ хийх тухай төлөвлөгөө, тушаал, шийдвэр одоогоор гараагүй байна.

Харин УИХ-ын Тамгын газрын хяналт шалгалт, үнэлгээний газар УИХ-ын холбогдох байнгын хороотой хамтран гурван удаа, Улсын Их Хурлын нэр бүхий гишүүний даалгаснаар хоёр удаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээг амжилттай хийсэн байна. Тухайлбал, 2022 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд үнэлгээ хийж тайланг www.parliament.mn цахим хуудаст байршуулсан байна[27].

Бидний зүгээс хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцах үүрэгтэй Монгол Улсын Засгийн газрын холбогдох яамд Үнэлгээ хийх үүрэг хүлээсэн нь эрх ашгийн зөрчил үүсгэж байгаа тул “зориудаар” үнэлгээ хийхгүй, мөн хөндлөнгийн байгууллагаар хийлгэхгүй байх магадлалтай гэж үзэж буй. Монгол Улсын Засгийн газар бол “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах”[28], түүний яамд нь “хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах”[29] үүрэгтэй. Гэтэл ийнхүү хууль хэрэгжүүлэх ажлыг хариуцсан этгээдэд хууль хэрэгжихгүй байгаа шалтгааныг судалж үнэлэх ажлыг хариуцуулах нь ийнхүү үзэх үндэслэл болов.

Онцлон дурдахад Үнэлгээг зөвхөн УИХ, түүний байнгын хороо, Засгийн газрын яамд, Хууль зүйн үндэсний хүрээлэн хийх бөгөөд ***“хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэх буюу хамтран ажиллаж болно”*** гэж заасныг анхаарах учиртай.[30]

Ийнхүү хуулийн цорын ганц хэрэгжих боломжтой хувилбар болох хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн Үнэлгээний дүнг хэлэлцсэн тухай ямар нэгэн баримт, мэдээлэл мөн олдсонгүй. Уг нь хуульд “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дүнг Улсын Их Хурал, Засгийн газар жилд нэг удаа тогтмол хэлэлцэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль тогтоомжийг хооронд нь уялдуулах, системчлэн кодификаци хийх, шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ”[31] гэж заасан.

Гэтэл хууль тогтоомжийн тухай хууль батлагдсанаас хойш ямар нэгэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дүнг Улсын Их Хурал, Засгийн газар хэлэлцсэн эсэх нь тодорхойгүй, Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт 2021 онд хийсэн үнэлгээгээр энэ Хуулийн 52 дугаар зүйлийн хэрэгжилтийг үнэлээгүй ажээ.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх байдал хангалтгүй байгаа нь УИХ, Засгийн газрын зүгээс хууль тогтоомжийн тухай хуулиар хүлээлгэсэн “жилд нэг удаа тогтмол хэлэлцэх” чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байгаагаас улбаатай бөгөөд төрийн байгууллагуудад нэгэнт тогтсон “дээрээс шахаж шаардаагүй зүйлийг хийддэггүй” хэвшмэл хандлагын дагуу УИХ, Засгийн газар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үүрэгтэй байгууллагуудыг хуулиар хүлээлгэсэн энэ “ажлаа хийхийг шахаж шаардахгүй” байгаатай холбоотой гэж үзэж байна.

---

[26] Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1”Улсын Их Хурал хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор ерөнхий хяналтын сонсголыг явуулна”.
[27] https://www.parliament.mn/nn/16729/
[28] Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг
[29] Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт
[30] Хууль тогтоомжийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийг үзнэ үү.
[31] Мөн хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дахь хэсэг

## НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТОЙМ: ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Өнөөгийн байдлаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ хийвэл зохих 267 хууль байна[32].

Юуны өмнө одоогоор Монгол Улсад хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ хийсэн байдлыг бүртгэсэн нэгдсэн бүртгэл болон сан байхгүйг дурдъя. Өөрөөр хэлбэл, Хууль тогтоомжийн тухай хуулийн “49.2, 49.3-т заасан үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13.7-д заасны дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн санд тухай бүр байршуулна” гэсэн заалт[33] одоогоор бүрэн хэрэгжээгүй байна.

Судалгаагаар одоогийн байдлаар нийтэд ил тод тавигдсан, бидний судалгаагаар олж тогтоосон 118 хуулийн Үнэлгээ олдов. Судалгааны явцад 1 хууль буюу Эрүүл ахуйн тухай хуульд үнэлгээ хийгдэж буй гэсэн мэдээлэл олдсон болно. Эдгээрийг үндэслэн 267 хуулийн 148 хуульд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдээгүй байна гэж үзэв.

*График 1. Хуульд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн субъект*




Ийнхүү хуулиудад хэрэгжилтийн үнэлгээ хийсэн байдлыг субъектээр нь авч үзвэл,

3 буюу нийт хийгдсэн Үнэлгээний 3.4 хувийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 49.1-ийн дагуу Улсын Их Хурлын байнгын хороо, УИХ-ын Тамгын газар;

16 буюу 18.8 хувийг н Хууль тогтоомжийн тухай хуулийн 49.2-ийн дагуу холбогдох Төрийн захиргааны төв байгууллага;

40 буюу 45.4 хувийг мөн хуулийн 49.3-ийн дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэн хийж гүйцэтгэжээ.

Түүнчлэн эдгээр үнэлгээний 29 буюу 32.9 хувийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 49.3-ийн дагуу хөндлөнгийн байгууллага дангаараа болон холбогдох байгууллагатай хамтран хийжээ.

Дээрх нөхцөл байдлаас үзвэл хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн захиргааны төв байгууллага дангаараа “үнэлгээ” хийх нь нэг талаар ашиг сонирхлын зөрчилтэй, нөгөө талаар үнэлгээ хийх мэргэжил-арга зүйн нөөц, ур чадвар хангалтгүй зэргээс үүдэн гол төлөв судалгааны байгууллагад захиалга өгөх буюу хамтран хэрэгжүүлж ирсэн байна. Яам, агентлаг өөрсдийн гардан хэрэгжүүлж буй хуулийн

[32] Хууль тогтоомжийн тухай хууль. 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг
[33] Мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.8 дахь хэсэг

хэрэгжилтийг үнэлэхдээ “байгууллагын эрх ашиг” буюу эрх мэдлээ хэрэгжүүлэх хууль зүйн боломжийг нэмэгдүүлэх, албан тушаалтны үйл ажиллагаанд амар дөхөм байдлаар зохицуулалт хийхийг чухалчлан үзэж “байгууллагын хууль” боловсруулахад үнэлгээний санал, дүгнэлт, зөвлөмжийг чиглүүлдэг байж болзошгүй. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын захиалгаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан”-д:

- шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид, судлаачдын зүгээс байгууллагын бүтэц, тогтолцоог шинэчлэх шаардлагатай гэж үздэг...
- шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулдаг эрхтэй байх...
- шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хугацаатай, тогтоосон хугацаанд төлбөр төлөөгүй бол хүү, алданги тооцох эрх зүйн зохицуулалттай болгох...
- шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллыг багасгах, тэнцвэржүүлэх, орон тоог нэмэгдүүлэх, ажлын байрны болон ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, ...алба хаагчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх...гм.

Гэхдээ төрийн захиргааны төв байгууллага захиалж хийлгэсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний бүх тайланг дээрх байдлаар байгууллагын эрх ашигт нийцүүлсэн гэж дүгнэх нь учир дутагдалтай хэдий ч мэргэжлийн, бие даасан судалгааны байгууллага, судлаачид захиалж хийлгэсэн судалгаанууд Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалыг илүү сайн баримталсан, бодит байдалд нийцсэн, хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэн зөв дүгнэлт, үр ашигтай санал, зөвлөмж өгсөн байгааг дурдах учиртай. Дээрх үнэлгээнүүдийн тайланг Хавсралтаас авч танилцана уу.

Үнэлгээг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу хийсэн байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд гурван хуульд буюу Хөдөлмөрийн хууль, Хууль зүйн туслалцааны тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн үнэлгээг Засгийн газраас батална өөр аргачлалаар, бусад хуулийг Засгийн газрын баталсан Аргачлалаар тус тус хийсэн байна. Хөгжлийн эхэн үедээ буюу Хууль тогтоомжийн тухай хууль дөнгөж батлагдсаны дараа Аргачлалыг бүрэн баримтлахгүй байсан тал ажиглагдаж байх бөгөөд 2018 оноос хойших Үнэлгээнүүд үндсэндээ батлагдсан Аргачлалын дагуу хийгдэх болжээ.

Тухайлбал, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбараас шалтгаалан 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгааг тогтоох үүднээс хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийжээ. Үнэлгээг тогтоосон Аргачлалыг яв цав баримтлан хийж, дараах хоёр үндсэн зөвлөмж өгсөн байна. Үүнд 1) Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсгээс “...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэсэн хэсгийг хасах; 2) Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ялын төрлийг нэмэх. Тухайлбал, “арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ялыг нэмэх” гэсэн тодорхой Зөвлөмж өгсөн байна[34].

Судалгаанд хамрагдсан нийт Үнэлгээний 45.4 хувийг Хууль зүйн үндэсний хүрээлэн хийсэн байх ба ингэхдээ ямагт Засгийн газрын тогтоолоор баталсан Аргачлалыг ямагт баримталж ирснийг энэ дашрамд дурдах нь зүйтэй.

Гэтэл Оюуны Инноваци ТББ-аас Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг 2024 онд хийхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Аргачлалыг баримталсан[35] гэх боловч тайлангийн агуулгатай танилцахад хуулийн зарим тодорхой зохицуулалт анх хуулиар тавьсан зорилгодоо хүрсэн эсэх, практикт хэрхэн хэрэгжиж байгаа,

[34] Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн хийсэн үнэлгээ.
[35] Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 7 дахь тал

тэдгээрийн хүлээн зөвшөөрөгдсөн байдал, урьдчилан тооцоолоогүй бусад үр дагавар зэргийг тодорхойлох ажлуудыг нэг бүрчлэн хийгээгүй байна. Гэсэн хэдий ч уг Үнэлгээ нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангахад зайлшгүй үнэлбэл зохих Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, дэлхийн улс орнуудын сайн туршлага зэргийг хамруулан цогцоор үнэлж чадсан, чанартай тайлан болсныг мөн хүлээн зөвшөөрөх нь зүйтэй болов уу.

Мөн 2025 онд "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ"-г Төрийн бодлогын шинжлэх ухааны доктор (Sc.D), Техникийн ухааны доктор (Ph.D) Д.Энхмаа, хуульч Я.Хишигт нар гүйцэтгэсэн байх бөгөөд Үнэлгээг 59 дүгээр тогтоолоор баталсан Аргачлалын дагуу гүйцэтгэсэн гэх боловч хуулийн хэрэгжилтийг 4 бүлэг 14 зүйл, 116 заалт тус бүрээр буюу аргачлалд дурдаагүй дэлгэрэнгүй арга зүй гарган хийж, "хуулийн хэрэгжилт 44.6 хувьтай байна" хэмээн дүгнэсэн нь ихээхэн сонирхол татаж байна. Тайлантай нарийвчлан танилцахад хуулийн зүйл, заалтын хэмжигдэхүйц байдлыг ихээхэн бодитой тодорхойлж, хуулийн хэм хэмжээг хэрэгжүүлэхийн тулд батлан гаргасан дүрэм, журмыг хүртэл нэгбүрчлэн судалсны үндсэн дээр хэрэгжилтийг хувьчлан гаргаж, нийт 21 зүйл санал, зөвлөмж өгчээ[36]. Өөрөөр хэлбэл, ийнхүү хуулийн хэм хэмжээний хэрэгжилтийг түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн хэм хэмжээний актаар хэрхэн нарийвчлан зохицуулж хэрэгжилтийг нь хангасан байдлыг үнэлэснийг шинэлэг гээд буй.

Дэлгэрүүлэн судалсан 88 тайлангаас үзэхэд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ хийх нь ямагт үр дүнтэй ажил болсон байх бөгөөд бүгд хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ач холбогдол бүхий санал зөвлөмж агуулж байв.

Цаг хугацааны хувьд авч үзвэл 2020-2024 оны хооронд дээр өгүүлсэн байнга дагаж мөрдөгдөх шинжтэй 352 хуулиас 50 хуулийг шинэчлэн найруулсан. Үүнээс 3 хуульд өөр аргачлалаар хэрэгжилтийн үнэлгээ хийсэн, 28 хуульд Аргачлалын дагуу хийсэн бол 19 хуульд Үнэлгээ хийсэн баримт олдоогүй болно. Нэг талаас ийнхүү зөвхөн тогтсон нэг Аргачлалаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх ажиллагааг хэвшмэл байдалд оруулж "хайрцаглахгүй" байх үүднээс Үнэлгээг өөр аргачлалаар хийж болох ч огт тогтсон Аргачлалгүй дур зоргын байдал үүсгэхгүй байх үүднээс цаашид дээр дурдсанчлан өөр аргачлалаар хийсэн үнэлгээг дэмжихгүй байх нь зүйтэй гэж үзнэ. Мөн хугацаанд 66 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны 29-д нь хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдсэн байх бол 37 хуульд үнэлгээ хийсэн эсэх нь тодорхойгүй буюу тайлан нь нийтэд нээлттэй бус байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг 2021 онд үнэлж, улмаар хуульд 2023 онд холбогдох нэмэлт өөрчлөлт оруулжээ. Энэхүү хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ болон Засгийн газрын тогтоолтой холбоотой зүйл, хэсэг, заалтад нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг. Тухайлбал, уг Үнэлгээгээр "хууль тогтоомжийн тухай хуулийн 50 дугаар зүйлийг хүчингүйд тооцож, хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх зохицуулах хасах", "хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хууль тогтоомжид бүхэлд нь хийх, эсхүл хэсэгчилсэн байдлаар буюу зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болохоор тусгах"[37] зэрэг зөвлөмж өгсний дагуу Хууль тогтоомжийн тухай хуулийн 50 дугаар зүйлийг хүчингүй болгож, 51 дүгээр зүйлийн 51.1, 51.3, 51.4, 51.5 дахь хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулсан38. Гэтэл хуульд орсон эдгээр өөрчлөлтөд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Аргачлалуудыг шинэчлэн нийцүүлээгүй, тэр ч бүү хэл уг тогтоолын 5

[36] Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ. УБ., 2025 он. 161-164 дэх тал
[37] Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээний тайлан. УБ., 2021. 22 дахь тал
[38] https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119

дугаар хавсралтыг хүчингүй болгоогүй хэвээр байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэхэд тавигдах шаардлагын дагуу ямар нэгэн байдлаар хуулийн төслийн бүрдүүлбэр дутуу буюу хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгээгүй бол УИХ-ын Тамгын газрын "босго"-ыг давж төслийг УИХ-д өргөн барих, хэлэлцүүлэх, батлах боломж "бараг" үгүй билээ. Үүнийг харгалзан үзвэл энэхүү судалгааны явцад Үнэлгээний тайлан нь олдоогүй хуулийн төсөл бүрд ямар нэг үнэлгээ хийгдсэн байх магадлалтай. Гэсэн ч тайлан нь олдохгүй байх тул чухам Үнэлгээ хийсэн эсэх, хийсэн ч Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор баталсан Аргачлалын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлох боломжгүй байв.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Аргачлалуудыг Хууль тогтоомжийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэх;
